



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г шинэчлэн батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1, 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г нэгдүгээр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрэх үр дүнг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Д.Ренчиндорж, үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Мөнхзул, хэрэгжилтийг авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, хүнд сурталгүй, ил тод нээлттэй, хурдан шуурхай зохион байгуулан хяналт тавьж, шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг үнэлж, тайлагнан ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирал М.Батгэрэл нарт тус тус даалгасугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүд, аймаг, дүүргийн зөвлөлд тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
0.1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд дараах үйл ажиллагаа буюу үйлчилгээ, арга хэмжээг хөдөлмөрийн насны хүн ам, зорилтот бүлэгт зориулан тухайн иргэний хэрэгцээнд үндэслэн сонгон хэрэгжүүлнэ. Үйлчилгээ, арга хэмжээг “Үйлчлүүлэгчид суурилсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ерөнхий зарчим, дараалал, зураглал”-ын дагуу зохион байгуулна.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулахдаа тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлог, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах чиглэлтэй уялдуулан (заавал, сонголтоор) хууль дээдлэх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод нээлттэй, шуурхай байх зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, энэхүү баримт бичигт дурдсан хэлбэр, агуулгаар зохион байгуулна.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Үйл ажиллагаа (хөтөлбөр)-г удирдлага, арга зүйгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт хангаж ажиллана.

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална.

2.3. Нэгдсэн удирдамжид нэр томьёо, ойлголт тодорхойлолт, үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим, дараалал, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах нөхцөл шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, үйлчилгээ, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.

ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан болон Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр тодорхойлсон бусад үйлчилгээг хамааруулна.

3.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ

Тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэд, ажил олгогч, олон нийтэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ.¹ Дараах хэлбэрээр зохион байгуулна:

¹ Үйлчилгээ хэрэгжүүлэхдээ ажилд зуучлах үйлчилгээтэй уялдсан хэлбэрээр зохион байгуулж, санхүүжүүлэх бөгөөд анкет, ажлын ярилцлагад бэлтгэх, аж ахуйн нэгж, байгууллагын хүний

3.1.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх;

3.1.2. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө өгөх.

3.2. Ажилд зуучлах үйлчилгээ

Аймаг, дүүргийн хөдөлмөрийн эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн болон ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучлах, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

3.2.1. Ажил хайгч², ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн³ болон ажил олоход хүндрэлтэй иргэнийг дараах үе шаттай зуучилна:

3.2.1.1. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling);

3.2.1.2. Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах (Individual employment planning);

3.2.1.2. Ажлын байранд бэлтгэх сургалтад шаардлагатай тохиолдолд хамруулах⁴;

3.2.1.3. Ажилд зуучлах (байнгын болон бусад);

3.2.1.4. Эргэх холбоо тогтоох (Feedback), дагалдах үйл ажиллагаа хэрэгжүүлэх (Follow up)

3.2.2. Ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:

3.2.2.1. Ажил олгогчид зориулсан зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах;

3.2.2.2. Ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажилтан олоход дэмжлэг үзүүлэх;

3.2.2.3. Ажил олгогч, сургалтын байгууллагын захиалгат арга хэмжээ (өдөрлөг, яармаг гэх мэт)

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний нэгдсэн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ

3.3.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэхдээ хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг ашиглана.

3.3.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж нь ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажил олгогчид хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил

нөөцийн бодлогод нийцсэн тест, асуулгад бэлтгэх, ажлын байр, үйлдвэрлэлтэй танилцуулах агуулгатай байж болно.

² Хүүхэд харах, асрах шалтгааны улмаас ажлын туршлага нь тасалдаж урт хугацаанд ажилгүй байсан иргэн, гадаадад ажиллаж амьдарч байгаад эх орондоо эргэн ирсэн иргэн, бага насны хүүхдээ асарч байгаа болон байнгын асаргаатай хүн асарч байгаа цагийн ажил хийх хүсэлтэй, боломжтой иргэн байж болно.

³ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.6-д заасан насанд хүрэх дөхсөн иргэн хамрагдаж болно.

⁴ Үйл ажиллагааны 4.1-т заасан Суурь ур чадварын сургалт.

олгогчийн захиалга⁵, шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг мэргэжлийн болон суурь ур чадварын сургалтаар дамжуулан бэлтгэх, цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх талаарх мэдлэгийг олгох замаар хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

Олон Улсын байгууллагын зээл, тусламжаар тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа туршилтын төслийн үр шим хүртэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулж болно⁶.

Сургалтын үйл явцын хяналт болон гүйцэтгэлд үр дүнгийн болон нөлөөллийн үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт хариуцан зохион байгуулна.

Сургалтын үйл ажиллагааг их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллага, мэргэжлийн сургалтын байгууллага, холбоодын нөөц, чадавхад тулгуурлан зохион байгуулна.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг⁷ хууль тогтоомжид нийцүүлэн энэ хөтөлбөр, дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрт заасан зарим агуулга, төрөл, хэлбэрээр зохион байгуулж болно.

4.1. Суурь ур чадварын сургалт

4.1.1. Суурь ур чадвар олгох сургалтыг дараах агуулга, хэлбэрээр зохион байгуулна:

4.1.1.1. Ажлын байр дахь зөөлөн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмж, сэтгэл зүйн эрүүл мэнд, цахим хэрэглээний мэдлэг олгох;

4.1.1.2. Хөдөлмөрийн харилцааны суурь ойлголтууд, ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны мэдлэг олгох.

4.2. Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт

4.2.1. Танхимын мэргэжлийн сургалт

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалга, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадварыг иргэнд богино хугацаанд олгох, давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор танхимын сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

4.2.2. Ур чадварын цахим сургалт

Эмэгтэйчүүд, ахмад настан, байнгын асаргаатай хүнийг асарч буй иргэдийн гэрээс зайнаас, цахимаар ажиллах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр суурь болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна.

4.2.3. Ажлын байр дээрх мэргэжлийн сургалт

Ажил олгогчийн захиалгад нийцсэн ажилтныг үйлдвэрлэлийн орчин, ажлын байр дээр дадлагажуулан сургах замаар ур чадвар олгох, ажлын байраар хангах хэлбэрээр сургалтыг зохион байгуулна.

4.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт

⁵ Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд хамрагдаж байгаа иргэдийн 60-аас доошгүй хувийг ажил олгогчийн захиалгаар хамруулна.

⁶ Азийн хөгжлийн банкны "Төгсөлтийн аргачлалын туршилт"-ын төсөл хамаарна.

⁷ Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн чадавхи нөөцөөс хамааран хөдөлмөрт бэлтгэх сургалтад хуваарилсан хөрөнгийн 15 хүртлэх хувийг хамтран зохион байгуулж болно.

4.3.1. Бизнес санаа хөгжүүлэх, төсөл бичих сургалт

Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэн, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн мэдлэг олгох, бизнес санаа хөгжүүлэх, төсөл боловсруулах агуулгатай сургалтыг зохион байгуулна.

4.3.2. Бизнес эрхлэх ур чадварын сургалт

Бичил бизнес, үйлчилгээ эрхлэгч нарын бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, төслөө амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор уг сургалтыг зохион байгуулна. Сургалтыг шаардлага хангасан бизнесийн зөвлөх (ментор)-ийн үйлчилгээ болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно⁸.

Гарааны бизнес, бичил бизнес, үйлчилгээ эрхлэгч нарыг бизнесээ өргөтгөхөд зориулсан уулзалт, хэлэлцүүлэг, туршлага судлах арга хэмжээг жилд 1 удаа зохион байгуулна.

ТАВ.САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнесийг эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бусад холбогдох дэмжлэг үзүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

Олон улсын байгууллагын зээл, тусламжаар тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа туршилтын төслийн үр шим хүртэгчдээс⁹ санхүүгийн дэмжлэгт хамруулж болно.

Уг үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ, үр дагаврын судалгааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт хариуцан зохион байгуулна.

5.1. Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг

5.1.1. Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг

Сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуй, бичил бизнес үйлдвэрлэл, үйлчилгээ¹⁰ эрхлэх хүсэлтэй иргэн¹¹, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын төгсөгчид Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан хэмжээ болон нөхцөлөөр эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэлх сарын хугацаатай олгоно. Хэрэв иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.

5.1.2. Үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулсан санхүүгийн дэмжлэг

Энэ үйл ажиллагааны 5.1.1-т заасан санхүүгийн дэмжлэгийг авч, төслөө амжилттай хэрэгжүүлэн эргэн төлөлтийг хугацаанд нь бүрэн төлсөн бичил бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нарт ажлын байр бий болгох, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зориулж санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан хэмжээгээр нэмэгдүүлэн олгож болно.

5.2. Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг

⁸ Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэний хүсэлтэд тулгуурлан сонголттойгоор /нэгтгэх, салгах/ зохион байгуулж болно.

⁹ Азийн хөгжлийн банкны "Төгсөлтийн аргачлалын туршилт"-ын төсөл хамаарна.

¹⁰ "Үйлчилгээ" гэдэг нь худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгааг хамааруулахгүй.

¹¹ Шалгаруулах үйл ажиллагааг "Нэгдсэн удирдамж"-аар зохицуулна.

5.2.1. 21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн малгүй болон бог малд шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийг Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан малжуулах санхүүгийн дэмжлэгт эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хамруулна.

5.2.2. Малжуулах санхүүгийн дэмжлэгт хамрагдсан малчин өрхөд зориулан дараах арга хэмжээг зохион байгуулна:

5.2.2.1. байгалийн гамшиг, эрсдэлт нөхцөлд бэлэн байдлыг хангах, мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалтын арга хэмжээнд хамруулна.

5.2.2.2. орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч болон борлуулалт, худалдааны сувагтай холбох замаар өрхийн үйлдвэрлэл, орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5.2.2.3. мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуйн туршлага солилцох арга хэмжээнд хамруулна.

5.3. Гарааны бизнес эрхлэгч залуучуудыг дэмжих санхүүгийн дэмжлэг

5.3.1. Улсын болон бүсийн хэмжээнд дэвшилтэт шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал санаачилга гаргаж, ногоон ажлын байр, өндөр ур чадвар шаардах болон технологийн ажлын байр бий болгох зорилготой төсөл боловсруулсан шилдэг гарааны бизнес эрхлэгч залуучуудын багийг /улсын хэмжээнд 1 дүгээр байр-нэг баг, 2 дугаар байр-хоёр баг, 3 дугаар байр-гурван баг, бүсийн хэмжээнд бүс тус бүр 1 шилдэг баг, 2-р байр 1 баг, 3-р байр 1 баг/ нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, эргэн төлөх нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэг олгоно.

5.3.2. Аймаг, дүүргийн хэмжээнд шилдэг гарааны бизнес эрхлэгч залуучуудын хоёр багийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, эргэн төлөх нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэг олгоно.

5.3.3. Гарааны бизнесийн санааг баяжуулах, өрсөлдүүлэх, хөгжүүлэх зэрэг арга хэмжээг их, дээд сургууль, бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар зохион байгуулж болно.

5.3.4. Дэмжлэгт хамрагдсан гарааны бизнес эрхлэгч залуучуудыг мэдлэг туршлага хуваалцах, бизнесээ өргөжүүлэх боломжоор хангах, амжилттай хэрэгжиж буй бизнесийг сурталчлах зэргээр дэмжлэг үзүүлнэ.

5.4. Бага насны хүүхэд болон байнгын асаргаатай хүнийг асарч байгаа иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг

5.4.1. Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 0-8 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг болон байнгын асаргаатай хүн асарч байгаа иргэн¹²-д Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан хэмжээгээр санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгоно. Хэрэв иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.

5.4.2. Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 0-8 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг болон байнгын асаргаатай хүн асарч байгаа иргэнийг бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулж дэмжлэг үзүүлнэ.

5.5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг

Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй сонгон шалгаруулалтад тэнцсэн ахмад (өндөр настны, цэргийн, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон хүн) настанд Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан

¹² Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний өдрийн болон гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг иргэн байж болно.

хэмжээгээр санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгоно. Хэрэв иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.

5.6. Мод ургуулах, арчлах арга хэмжээ¹³ний санхүүгийн дэмжлэг

Мод ургуулах, арчлах, орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэн, иргэдийн бүлэгт ажлын үр дүнд¹⁴ тулгуурлан тэдний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан хэмжээгээр санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгоно¹⁵.

5.7. Ажил олгогчийг дэмжих

5.7.1. Ажилгүй иргэнийг¹⁶ 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангаж, тогтвортой ажиллуулж байгаа ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгоно. Урамшууллыг тухайн байнгын ажилтай болсон иргэн бүрээр тооцон тухай бүр олгоно.¹⁷

5.7.2. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7) иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байрны тоогоор тооцож нэг удаа олгоно.

5.8. Түрээсийн дэмжлэг үзүүлэх

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан гэрээний хугацаа хүчинтэй байгаа иргэн, аж ахуйн нэгжид, түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, газар дээрх нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт¹⁸-ийг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан нягталж, төлбөр төлсөн баримтын дүнгээр нөхөн олгоно.

Тус дэмжлэгт ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор орон нутаг дахь ахмадын төвийг хамруулж болно.

5.9. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн болон бусад дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт борлуулалтын цэг ажиллуулах, төрөлжсөн худалдааны цахим хуудастай хамтарч ажиллана.¹⁹

ЗУРГАА. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тэдгээрийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тохируулгатай ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах, ажил олгогчийг дэмжихэд чиглэсэн

¹³ "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ.

¹⁴ Модны ургалт, модны тоо хэмжээ, ойжуулсан талбайн хэмжээний өсөлт зэргийг харгалзан үзнэ.

¹⁵ Уг арга хэмжээнд иргэн ганцаарчлан болон бүлгээр/баг болох/ хамрагдаж болно.

¹⁶ Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлснээс хойш 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадаагүй иргэн байна.

¹⁷ Ажлын байртай болсон иргэнийг тус урамшуулалд давтан хамруулахгүй.

¹⁸ "Нэгдсэн удирдамж"-ийн зардлын жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүй байна.

¹⁹ Цахим хуудасны хандалтыг холбогдох төрийн байгууллагын хандалтын мэдээлэлд үндэслэнэ.

үйлчилгээ, арга хэмжээг (дохионы хэлмэрч, ажлын байрны тохируулга г.м) хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Олон улсын байгууллагын зээл, тусламжаар тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй туршилтын төслийн үр шим хүртэгчдээс²⁰ оролцуулан хамруулж болно.

6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ (Job Coaching)

6.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах иргэнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын баталсан аргачлал, удирдамжийн дагуу цогц үнэлгээг хийж, үнэлгээнд үндэслэн, зөвлөгөө өгч, хувийн төлөвлөгөө боловсруулж дэмжин ажиллана.

6.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

6.1.2.1. Хувь хүн, гэр бүлд харилцаа хандлага, сэтгэл заслын сургалт хийх, зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээ байгуулах;

6.1.2.2. Үнэлгээнд үндэслэн хувийн төлөвлөгөө боловсруулах;

6.1.2.3. Ахуйн дэмжлэг буюу хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, шалтгааныг арилгах зорилгоор төрийн бусад үйлчилгээнд хамруулах, зуучлах, чиглүүлэх;

6.1.2.4. Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалан ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй иргэдийг нийгэмшүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажил хөдөлмөрийн ойлголт, ажил хөдөлмөрийн анхан шатны дадал суулгах зорилгоор зорилтод ажлын байр буюу халамжийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах;

6.1.2.5. Өвчин, осол, гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон, халамжийн хөдөлмөр эрхлэх үйлчилгээнд хамрагдахаар үнэлэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд дахин ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлж хөдөлмөрийн нөхөн сэргээлтийн үйлчилгээнд хамруулах;

6.1.2.6. Ажил хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх;

6.1.2.7. Бизнес инкубациар дамжуулан хувиараа бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

6.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдаж буй хүн бүрийг энэхүү хөтөлбөрийн 6.1.2.1, 6.1.2.2-д заасан үйлчилгээг үзүүлнэ.

6.1.4. Иргэний үнэлгээ болон хувийн төлөвлөгөөнд үндэслэн энэ хөтөлбөрийн 6.1.2.3-т заасан үйлчилгээнд хамруулахгүй байж болох ба 6.1.2.4-6.1.2.6-д заасан үйлчилгээг сонголтоор үзүүлнэ.

6.1.5. Иргэн энэхүү хөтөлбөрийн 6.1.2.4-6.1.2.5-д заасан үйлчилгээнд хамрагдаж дуусаад 6.1.2.6 болон 6.1.2.7-д заасан үйлчилгээнд шатлан хамрагдаж болно.

6.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг шаардлага хангасан, чадавхи бүхий төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

6.2. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

6.2.1. Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхэлж, ажлын байр бий болгох зорилготой хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ

²⁰ Азийн хөгжлийн банкны "Төгсөлтийн аргачлалын туршилт"-ын төсөл хамаарна.

гэртээ асарч байгаа (давхар хөдөлмөр эрхэлдэггүй) хүний боловсруулсан төслийг шалгаруулж, Засгийн газраас тогтоосон хэмжээгээр барьцаагүй, хүүгүй, санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаанд 50 хувийг нь эргэн төлөх нөхцөлтэй олгоно. Иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.

6.2.2. Аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, ажлын байрны тохируулга, технологио шинэчлэх, шинээр бий болгосон ажлын байраа хадгалах, шинээр тохируулгатай ажлын байр бий болгож хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тогтвортой ажиллуулах тухай төсөлд нэг ажлын байранд 10.0 сая хүртэл төгрөгөөр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр, барьцаагүй, хүүгүй, санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаанд, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид Засгийн газраас тогтоосон хэмжээгээр санхүүгийн дэмжлэгийг 48 хүртэл сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгоно. Сонгон шалгаруулалтыг гурван үе шаттай зохион байгуулна.

6.3. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа

6.3.1 Аж ахуй эрхлэлтийн сургалт

6.3.1.1. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шаардлагатай тохиолдолд 4.3.1, 4.3.2-т заасан сургалтыг зохион байгуулна.

6.3.1.2. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийг бизнесээ өргөтгөхөд зориулсан уулзалт, хэлэлцүүлэг, туршлага судлах арга хэмжээг жилд 1 удаа зохион байгуулна.

6.3.2. Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт

6.3.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/310, А/130 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "мэргэжлийн сургалтын байгууллагад тавих шаардлага"-ыг хангасан, тохируулгатай сургалтын орчин бүрдүүлсэн сургалтын байгууллагатай батлагдсан хөтөлбөрийн дагуу гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

6.3.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл сонирхол, мэргэжил ур чадварт нь тохирсон мэргэжлийн чадамж эзэмшүүлэх танхимын болон үйлдвэрлэл дээрх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг сонгон зохион байгуулна.

6.3.2.3. Сургалтын арга хэмжээний хүрээнд хөтөч, дохионы хэлмэрч бэлтгэх болон дохионы хэл заах, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалт болон хэрэгцээ шаардлагатай нэмэлт сургалтыг хийж болно.

6.4. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг

6.4.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй хүн, мөн нийт ажилтны 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй аж ахуйн нэгж, байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, бизнес инкубатор төвийн бойжигчид гэрээний хүчинтэй хугацаагаар тооцон тухайн жилийн 6 хүртэл сарын хугацаанд түрээсийн төлбөрийн дэмжлэгийг олгоно.

6.4.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтын

дэмжлэгийг үзэсгэлэн зохион байгуулах, нэг удаагийн борлуулалт хийхэд холбон зуучлах, байнгын борлуулалтын сувгийг сонгоход дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.²¹

6.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг

6.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангаж, цалин олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно.

6.5.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тогтоосон хувиас илүү гарсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас илүү гарсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг тус бүр нэг удаа олгоно.

6.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа

6.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ;

6.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ;

6.6.3. Үндэсний хэмжээнд хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн оролцоог сайжруулах судалгаа хийх, аж байдлын судалгааны бэлтгэл ажлыг хангана;

6.6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх сайн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил хийнэ;

6.6.5. Дэлхийн ур чадварын Абилимп олон улсын тэмцээнийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ;

6.6.6. Хөдөлмөр эрхэлж буй сонсголын бэрхшээлтэй хүнд зайнаас зөвлөн туслах, уулзалт хэлэлцүүлэг, дүрс бичлэгт дохионы хэлмэрчийн үйлчилгээ үзүүлнэ;

6.6.7. Төрийн бус байгууллагуудын хүний нөөцийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулна;

6.6.8. Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэхэд зориулж хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, хувийн туслах бэлтгэх сургалт зохион байгуулах, олон нийтэд түгээнэ;

6.6.9. Ажлын байрны дадлагажуулагчийг бэлтгэх, үйлчилгээ үзүүлнэ.

ДОЛОО.ТҮР АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ БОЛОН АХМАД НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, амьдарч буй орчны нийтийн эзэмшлийн зам, талбайг сайжруулах чиглэлээр ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон эзэмшсэн мэдлэг, туршлагадаа үндэслэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр

²¹ Нэгдсэн удирдамжид заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга удирдлага, зохион байгуулалтаар хангана.

эрхлэх хүсэлтэй ахмад настныг түр ажлын байраар хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

7.1. Мод ургуулах, арчлах арга хэмжээ²²

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, иргэдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, ажилгүй иргэн болон ахмад настны оролцоог хангах, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод услах, арчлах, орчныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.

7.2. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ²³

Ахмад мэргэжилтний ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, эзэмшсэн мэдлэг, ажлын туршлагыг хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг сургалт, ментор, дадлагын хэлбэрээр үзүүлэх байдлаар зохион байгуулна.

7.2.1. Ахмад мэргэжилтний мэдээллийн сан үүсгэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хэрэгцээт дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж зөвлөх үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

7.2.2. Ахмад мэргэжилтнийг эрүүл мэнд, боловсрол, аялал жуулчлал болон бусад салбарын улирлын чанартай ажлын байранд холбон зуучлан ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

7.2.3. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, мэдээлэл холбоо зэрэг салбаруудын өндөр ур чадвартай, туршлагатай ахмад ажилтан болон өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнийг бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг чадавхижуулах сургагч багш, ментороор ажилуулах замаар зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулж болно.

7.3. Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ

Тухайн орон нутгийн ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ зохион байгуулна.

Ахмадын холбоо, төрийн бус байгууллага нь орон нутгийн ахмадын хөдөлмөр эрхлэх, нийтлэг эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай, зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байна.

7.4. Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Аймаг, дүүргийн Цагдаагийн газар, хэлтэс болон Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар, хэлтэс нь ахмад настныг ²⁴ сонгон авч, холбогдох сургалтанд хамруулах, хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай хамтран ажиллах, мэдээллээр хангаж, гэрээ байгуулан хүүхэд эрсдэлд орж болзошгүй орчинд хүүхдийг эрхийг хамгаалах чиглэлээр ажиллуулна.

НАЙМ.ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

²² “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ.

²³ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

²⁴ Боловсролын байгууллага, хүүхдийн байгууллага, цэрэг, цагдаагийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага болон бусад төрийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан иргэн байна.

Монгол Улсын Засгийн газрын бодлого, хөтөлбөртэй уялдсан байдлаар цаг үеийн шинж чанартай тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ байх бөгөөд хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагуудын хэрэгжүүлэхээр тодорхойлсон хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх цаг үеийн шинж чанартай арга хэмжээ, төслийг хэрэгжүүлнэ.

8.1. Засгийн газраас болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусгайлан боловсруулах, батлагдсан журмын хүрээнд хэрэгжүүлж ажиллана.

8.1.1. “Жоб Центр” туршилтын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ;

8.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, гадаадад ажиллаж амьдарч байгаад эх орондоо эргэн ирсэн иргэний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд зориулсан “Хөгжлийн гүүр төсөл”-ийг Жижиг дунд үйлдвэрийн газартай хамтран хэрэгжүүлнэ;

8.1.3. Хөдөлмөрийн харилцааг дэмжих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;

8.1.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлнэ;²⁵

8.1.5. Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ²⁶ үзүүлнэ.

--- оОо ---

²⁵ Хөдөлмөрийн хуулийн 63.3 дагалднаар суралцах ажилтан

²⁶ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)-НЫ ХҮРЭХ ҮР ДҮН

Үйл ажиллагаа	Үйлчилгээ, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	2024 он	2025 он	
			Суурь түвшин	Зорилтот түвшин	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээ	1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээнд хамруулсан хүний тоо	20,414	17,000	
		2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгээр зохион байгуулсан зөвлөх үйлчилгээнд хамруулсан хүний тоо	48,826	22,500	
	Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling)	3. ХХҮГ-аар үйлчлүүлсэн ажилгүй эсхүл ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэх иргэдээс профайлинг үйлчилгээнд хамруулсан хүний тоо	13,011	40,000	
		Ажилд зуучлах	4. Хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө боловсруулах	5,320	32,000
	5. Ажилд зуучлах		21,469	29,900	
	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа	Суурь ур чадварын сургалт	6. Цагийн ажлын байранд зуучлагдсан хүний тоо	4,051	3,000
			7. Суурь ур чадварын сургалтад хамрагдсан хүний тоо	7,027	6,730
		Чадамжид суурилсан мэргэжлийн	8. Танхимын мэргэжлийн сургалт	1,300	3,000
	9. Ур чадварын цахим сургалт		935	1,500	

сургалт	сургалт	тоо	тоо	тоо	
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Ажлын байр дээрх сургалт	10	Мэргэжлийн сургалтад (үйлдвэрлэл дээрх) хамрагдсан иргэдийн тоо	163	
	Аж ахуй эрхлэлтийн сургалт	Бизнес санаа хөгжүүлэх, төсөл бичих сургалт	11	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	4,282
		Бизнес эрхлэх ур чадварын сургалт	12	Сургалтад хамрагдсан иргэдээс жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн хувь	55
		Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	13	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2,573
	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	14	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	1,572
		Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд санхүүгийн дэмжлэг	15	Санхүүгийн дэмжлэг авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь	53
		Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг	16	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	-
		Мал маллах арга ухаан, малын ашиг шим боловсруулах сургалт	17	Санхүүгийн дэмжлэг авсан малчин өрхийн тоо	3,295
		Шилдэг "Старт-Ап" залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэг олгох	18	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1,541
	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг	19	Гарааны бизнесийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуучуудын тоо	45	
					170
					4,300
					60
					3,500
					1,700
					50
					150
					1,100
					1,600
				102	

ОЛГОХ	"Старт-Ап" залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг, сургалт, зөвлөгөө, менторын үйлчилгээ	20	Гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан залуучуудын тоо	30	30
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	Ажил олгогчид урамшуулал олгох /6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан/	21	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмадын тоо	1,414	1,000
	Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох /асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангасан/	22	Байнгын ажилтай болсон иргэдийн тоо	42	110
Түрээсийн дэмжлэг үзүүлэх	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт	23	Байнгын ажилтай болсон иргэдийн тоо	-	30
Хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээ	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт	24	Арга хэмжээнд хамрагдсан аж ахуй эрхлэгчийн тоо	203	500
	Иргэн	25	Хамрагдсан хүний тоо	-	300
Санхүүгийн дэмжлэг	Аж ахуй нэгж	26	Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн тоо	735	550
	Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч	27	Санхүүгийн дэмжлэг авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо	12	20
Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа	Аж ахуй эрхлэлтийн сургалт	28	Санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо	30	12
	Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт	29	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1,140	1,150
		30	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	339	400

**Хөгжлийн
БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭНИЙ
ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР**

Ажлын байрны түрээсийн дэмжлэг	Түрээсийн дэмжлэг	31	Ажлын байрны түрээсийн дэмжлэгт хамрагдсан ХБИ-ээс ажлын байраа хадгалсан иргэний эзлэх хувь	-	100
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг	Ажил олгогчид урамшуулал олгох /ХБИ-ийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогч/	32	25-аас доош ажил олгогчийн тоо	29	71
Мод ургуулах, арчлах арга хэмжээ	Ажил олгогчид урамшуулал олгох /ХБИ-ийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогч/	33	25 ба түүнээс дээш ажилтантай ажил олгогчийн тоо	2	25
Тур ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	Мод ургуулах, арчлах арга хэмжээ	34	Хамрагдсан хүний тоо	2,705	3,000
Хөдөлмөр эрхийг хамгаалахад үзүүлэх үйлчилгээ	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	35	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж ажлын байртай болсон иргэдийн тоо	1,156	1,725
Хүүхдийн эрхийг үзүүлэх үйлчилгээ	Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ	36	Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн холбоо, төрийн бус байгууллагын тоо	10	40
Хөдөлмөр эрхийг үзүүлэх үйлчилгээ	Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	37	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /ахмад/	200	543
Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр, төсөл,	"Жоб центр" төсөл	38	Байгуулагдсан төвийн тоо	4	30
Хөдөлмөр эрхийг үзүүлэх үйлчилгээ	"Хөгжлийн гүүр" төсөл	39	Хамрагдсан ААНБ тоо	-	20
Хөдөлмөр эрхийг үзүүлэх үйлчилгээ	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр	40	Хамрагдсан иргэдийн тоо	-	5,000
Хөдөлмөр эрхийг үзүүлэх үйлчилгээ	Хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо	41	Хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо	-	300



ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх	42	Дэмжлэгт хамрагдсан суралцагчдын тоо	-	300
	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ	43	Хамрагдсан иргэдийн тоо	-	110

--- оОо ---

